

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэлд:

"ХХ.2. Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтцийг барихад хөрөнгө оруулах сонирхолтой гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн ажлын явцын талаар Зам, тээврийн сайд А.Гансүх Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I, II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий тусгай зориулалтын "Шинэ төмөр зам" ХХК-ийг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн охин компанийн хэлбэрээр байгуулах, тус компанид хөрөнгө оруулах сонирхолтой гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээ хийх урилгыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Төрийн өмчийн хороонд даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР